МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 25 өдөр Дугаар А/295 Алтай хот

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны мн/114 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хуралдаанаар Монгол Улсад үүсээд байгаа цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2021 оны нэгдүгээр ээлжийн цэргийг татахгүй байхаар шийдвэрлэсэн тул аймгийн Засаг даргын 2021 оны А/144 дүгээр захирамжийн 2, 3 дугаар заалтуудыг хүчингүй болгосугай.

2.Цэргийн дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх ажлын хүрээнд Цэргийн штабыг "Байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө", "Орон нутгийн цэргийг байгуулах төлөвлөгөө"-г тус тус Зэвсэгт Хүчний Жанжин штабын даргаар батлуулах ажилд зарцуулах шатахуун, томилолтын зардалд 5,903,850 (таван сая есөн зуун гурван мянга найман зуун тавин) төгрөгийг зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын үйл ажиллагаанд төлөвлөгдсөн зарим зардал 7,960,400 (долоон сая есөн зуун жаран мянга дөрвөн зуун) төгрөгийг 2021 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын ажиллагаанд шилжүүлэн зарцуулахыг Цэрэг татлагын товчоо (Ц.Батзориг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цэрэг татлагын товчоо (Ц.Батзориг)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4.doc

0201000882